

Б. Ринчен абугайн өвөг дээдэс


Ж. Гэрэлбадрах

"buriyad toyin güši-yin aq-a degüü yurban-dur irege-edüi čaγ-un bayidal-un duridqal orusiba"
(Буриад тойн гүүшийн ах дүү гурванд ирээдүй цагийн байдлын дурдатгал оршив) хэмээх XVII зууны Монголын түүхийн нэгэн багавтар зохиолд Б. Ринчений дээд өвөг Халхын Цогт тайжийн ач хөвүүн Охин тайжийн талаар өгүүлдэг.


"buriyad toyin güši-yin aq-a degüü yurban-dur irege-edüi čaγ-un bayidal-un duridqal orusiba"
(Буриад тойн гүүшийн ах дүү гурванд ирээдүй цагийн байдлын дурдатгал оршив)-ын хамрах он цагийн хүрээ богино, өгүүлэмж товч. Монгол хаадын угсааг Чингис хаанаас Тогоонтөмөр хаан, Билигт хаанаас Лигдэн хаан хүртэл маш товч дурджээ. *"qalq-a dörben ayimaγ, öbür doluγan čiyulγan, ordus doluγan qošiyun-u noyad ber qamtu-yin sanaγ-a neyilegülkü yeke čiyulγan bolqu čaγtur,"* (Халх дөрвөн аймаг, өвөр долоон чуулган, Ордос долоон хошууны ноёд бээр хамтын санаа нийлүүлэх их чуулган болох цагт) буюу 1691 онд болсон Халх Монголыг Манжид дагаар оруулах Долоннуурын чуулган дээр Охин тайжийн үүсгэсэн хэрэг явдал, түүнээс улбаалсан дүрвэн нүүх хөдөлгөөний талаар өгүүлдэг.¹

Уг зохиолыг Авга хошууны Тойн гүүш-хэмээх лам 1696 оны үед Манжийг эсэргүүцсэн Охин тайжийг дагаж Орос руу одсон өөрийн ойрын хамаатан ах дүү гурвыг буцааж аваачихаар Хорь Бабучи баатрын нутгийн Хотон хэмээх ууланд хорь гаруй хоног байхдаа бичсэн байна.


Охин тайж гэж хэн бэ? Охин бол Монголын хаадын Боржигин овгийг үндэслэгч Бодончарын 30-р, Монголын анхны хаан Хабулын 23-р үеийн ач хөвүүн юм. Түүний дээд удам угсааг дүрслэн үзүүлбэл,




¹ *"buriyad toyin güši-yin aq-a degüü yurban-dur irege-edüi čaγ-un bayidal-un duridqal orusiba"*, хэвлэлд бэлтгэсэн Ж. Гэрэлбадрах, УБ., 2005. (хэвлэлд)



Охин тайжийн удам угсааг цааш хөөвөл эхийн талаараа XX зууны Монголын их бичгийн хүн Б. Ринчен дээр ирдэг. Үүнийг үзүүлбэл,





Б. Ринчен абугай энэ тухай өөрийн намтартаа тодорхой өгүүлсэн байдаг. Тэр ч байтугай түүний эх Дуламд уг сурвалжийн нэг эх хадгалагдаж байсан байна.² Буриадын аман түүхийн мэдээгээр Охин тайж Мөнх хоёр нэг үеийн хүмүүс төдийгүй Авгын хошуудаас зугадан ирсэн анд нөхөд байв.³ Тэр хоёрын удам угсаа 8-р үе дээрээ ураг холбосон нь Б. Ринчений эцэг, эх болж байна.

Охин тайжийн өвөг эцэг Цогт хунтайж Монголын сүүлчийн хаан Лигдэний улс төр-шашны холбоотон байж, Хөх нуурт очоод 1636 онд Ойрадын Төрбайх ноёны цэрэгт дарагдан нас баржээ. 1640 оны “Дөчин, дөрвөн хоёр”-ын чуулганаар Халхын Цогт хунтайжийн харъяат нараас Ойрадад ойн одогсдыг тэнд нь шингээхээр тогтоожээ. Тус чуулганаас баталсан “Их цааз” хуулинд “*coqtuyin oyirodtu oroqsan kümün bosbāsu oyirodtu xariülji öq*” (Цогтын Ойрадад орсон хүн босвоос Ойрадад хариулж өг)⁴ хэмээн заажээ. Тийнхүү Халхын нутгийн гаднах Цогт хунтайжийн харъяат нарыг нэхэмжилж авах хууль ёсны үндэслэлгүй болсон тул Хөх нуурт байсан түүний хөвгүүн Хонтугур Өвөр Монголын Шилийн голчин чуулганы Авга, Авга нарын хошуунд очжээ.

Ингэхдээ Цогт тайжийн хөвгүүн Хонтугур Авга хошуудад шууд ороогүй бөгөөд “*qoortu boγtu noyan-u köbegün qongtuyur ber aru öbür qoγurundu egeljilen yabuqu-yin jayur-a,*” (Хорт Цогт ноёны хөвүүн Хонтугур бээр ар өвөр хооронд ээлжлэн явахын зуураа) буюу Халх, Өвөр Монголын хооронд хэсэг хугацаанд харьяалалгүй явж байжээ. Түүний Авга хошуудад ороход элэнц эхийн угсаа гарал зохих хэмжээгээр нөлөөлжээ. “Шар тууж”-ид өгүүлснээр “*baqarai qosiyuci baγatur-un qatun inu ongnid-un berke-yin ökin tayiqu qatun*”⁵ (Бахарай хошууч баатрын хатан нь Оннидын Тайху хатан) ажээ. Тэрбээр “*cing bisireltü sayin madi taiqal qatun*” (чин бишрэлт сайн мади тайхал хатан) хэмээн алдаршсан нэгэн билээ.

Оннигуд нь урьдын бөх Бэлгүдэйн удмынхны захирч байсан аймаг бөгөөд XVII зууны үеэс Авга, Авга нар аймаг хэмээн нэрлэгдэх болсон ажээ.⁶ Тэрбээр элэнц эхийн талыг барьж Авга хошуудад орсон байна. “*lledkel šastir*” (илтгэл шастир)-т Бэлгүдэйн 18-р үеийн ач Байсху бүргэд, Номи тэмээт нарын харъяат аймгийг Авга, Авга нар хэмээн нэрийдэх болсныг дурджээ.⁷

Хонтугур нь Цогт тайжийн хөвүүн мөн үү? Цогт тайж таван хөвүүнтэй. Тэдгээрийг дурдвал “*včir ayimaγ-un arslan, radn-a erdeni, lingqu sečen dayicing, garm-a jüg-ün jayan, asaral erke dayičing*”⁸ (Очир аймгийн Арслан, Раднаа эрдэнэ, Линху сэцэн дайчин, Гармаа зүгийн Заан, Асрал эрх дайчин) нар юм. Хонтугур нь Цогт тайжийн сул хатны хөвүүн бололтой. Гэхдээ үүнийг нотлох өөр дорвитой мэдээ өнөө хэр байхгүй байна.

Сурвалжид Охин тайжийн эцэг Хонтугур болохыг “*qongtuyur kemegči tegün-ü küü ene öqin mōn*” (Хонтугур хэмээгч түүний хүү энэ Охин мөн) хэмээн заагаад түүнийг “*mingjür vang-un γurbaduγar tayiji-yin ökin-eče törügsen-iyer, ökin-ü küü ökin kemen nereyidügsen*” (Минжүүр вангийн гуравдугаар тайжийн охиноос төрснөөр, охины хүү Охин хэмээн нэрийдсэн) хэмээн тайлбарлажээ. Охин тайжийн ээж нь гутгаар зэргийн тайжийн охин ажээ. “*lledkel šastir*” (илтгэл

² Бямбын Ринчен, Монголын Шинжлэх Ухаан, боть V, УБ., 2003, т.140-141

³ Сайт Бурятского народа – Форум. <http://www.buryatia.forum>

⁴ Их цааз-Великое уложение, Памятник Монгольского феодального права XVII в, М., 1981, стр.126

⁵ Шара туджи, Монгольская летопись XVII века, Сводный текст, перевод, введение и примечания Н. П. Шастиной, М.-Л., 1957, стр. 117

⁶ Н. Хатанбаатар, Халхын Цогт тайжийн намтарт холбогдох зарим түүхэн мэдээг нягтлах нь, Acta Historica, t. VI, 2005, (хэвлэлд)

⁷ Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван, гүнүүдийн илтгэл шастир, УТА, дэвтэр. 37, 38

⁸ Шара туджи, Монгольская летопись XVII века, Сводный текст, перевод, введение и примечания Н. П. Шастиной, М.-Л., 1957, стр. 91

шастир)-т түүний эцэг Авгын Минжүүр вангийн нэр гарахгүй байгаа тул Охин тайжийн ээж Авга хүн биш байж ч болох юм.

Охин тайж 1691 оны Долоннуурын чуулганы үйл ажиллагааг тасалдуулахыг оролдож, Манжийн эсрэг шууд илээр мөчөөрхөн тэмцсэн байна. "*γurban edür udaγ-a kituγ-a-ban qančuuilaju, kimusu-ban kisun bayiqu ene inü küčün bayibasū, qoortu kimural γarγaqu sanaγ-a*" (гурван өдөр удаа хутгаа ханцуйлж, хумсаа хясан байх энэ нь хүчин байваас, хорт хямрал гаргах санаа)-тай байв. Түүний эл ажиллагаа бүтэлгүйтэж, Түмэдийн ноён Эрдэнэ хунтайжийн зарлигаар баригдан хоригджээ.

Гэвч Охин тайж хорионоос зугадан гарч харъяат нар дээрээ ирээд Авгын зарим ноёдтой нийлэн хойд зүг дүрвэн зугадсан байна. Энэ тухай сурвалжид "*ökin-i bariju jandalaγsan-ača aldayulun dutaγaju γaruγsan darui, abayas-un noyad-tur qongtuγur-i qošiγin-dayan baytaγaju, qoortu šimnus arbijiγulunam ta kemen jakiγsan-dur, aγurlaju, dumda-ača doluγan čola-yin qariyatan jaγun tabin quyaγ ulus-i qota-bar abču uγtuγučan mordaqui-dayan*" (Охиныг барьж зандалснаас алдуулан дутааж гарсан даруй, Абагасын ноёдод Хонтугурыг хошуундаа багтааж, хорт шимнус арвижуулам та хэмээн захисанд, уурлаж, дундаас долоон цолын харъяатан зуун тавин хуяг улсыг хотоор авч угтцан мордохдоо) хэмээн өгүүлжээ.

Тэд нутгаасаа явахын өмнө мөргөл үйлдэн нэгэн үзүүрт сэтгэлээр хамт байх тангараг өргөжээ. Тэднийг "*bügüdeger čiyulju, sanaγ-a neyilegülijü, šitügen-ü emün-e mörgüjü tangγaraylan, emegel-ün niγur, toqum-un amsar-i neyilegülen, sön tosun-iyar (milaγaju) milayaju, dotuγadu qormui-yuγan barilčan, mingγan on-u dotuγši martal ügei yabuju, maγad nigen qamturiy-a kemen irüger talbilčaju, toqum-un amsar-i gedergü toquju mordaluγ-a*" (бүгдээр чуулж, санаа нийлүүлж, шүтээний өмнө мөргөж тангараглан, эмээлийн нүүр, тохмын амсрыг нийлүүлэн, сүү тосоор (мялааж) мялааж, дотоод хормой юугаа барилцан, мянган оны дотогш мартал үгүй явж, магад нэгэн хамтарья хэмээн ерөөл тавилцаж, тохмын амсрыг гэдрэг тохож мордлоо) хэмээн бичсэн байна.

Охин тайж нар нутгаасаа чанх хойд зүг нүүн явах замдаа Мэнэнгийн талаар дайран Буйр, Хөлөн нуурын баруун талаар гаран Оросын нутагт орсон байна. Чингэж явахдаа Мэнэнгийн талд нутаглах хүн ардыг уулгалан довтолж өнгөрчээ. Тэр үед Халхад Ойрадын цэрэг байсан тул Манж нар Охин тайж нарыг цэргийн хүчээр хөөн байлдаж чадаагүй, сулд нь орхижээ.

Охин тайж болон Авгын ноёдын дүрвэлт тухайн үедээ ихэд хөлтэй явдал болсон төдийгүй нийтийг хамарсан дүрвэн нүүх хөдөлгөөн болох дөхсөн байна. "*kimural olan degdegsen-eče olan ulus qotabar orγuqu-yi jabduγsan*" (хямрал олон дэгдснээс олон улс хотоор оргохыг завдсан) хэрэг гарч, Манж нарыг ихэд сандаргажээ. Иймд Охин тайжийг ганцаараа бус, түүний толгойлсон Өвөр Монголын хэсэг ноёд Манжийн эсрэг үймээн дэгдээсэн хэмээн үзнэ.

Охин тайж нар Оросод очоод эргэн Манжийн эсрэг тулалдсан болов уу гэмээр мэдээ эл сурвалжид байна. "*qoortu sanaγ-a-tu ökin qudal-iyar qobsurču, čerig olju, orus-un ner-e bariju, dayilaju qoγusun bolγabai.*" (хорт санаат Охин худлаар ховсорч, цэрэг олж, Оросын нэр барьж, дайлж хоосон болгов.) хэмээсэн нь бодвол тэднийг нэхэн очсон Манжийн цэрэгтэй байлдан ялсан хэрэг болов уу. Гэхдээ тэр үед Халхын нутаг Ойрадын Галдан бошготын мэдэлд байсан тул эл мэдээ эргэлзээтэй.

Охин тайж Оросын харъяат болохын тулд Манжийн эсрэг үймээн дэгдээж, дүрвэн зугатаагүй юм. Тэрбээр тусгаар байхыг зорьсон боловч тухайн цаг үеийн нөхцөл байдлын улмаас гарах гарцгүй болсон тул аргагүйн эрхэнд Оросод дагаар орсон ажээ.

Тийнхүү Охин тайж нар 1691 оны 5 сард нутгаасаа дүрвэн гарч Оросын нутагт орсон. Оросууд хэсэг хугацааны дараа тэднийг баруун тийш нүүлгэж Байгал нуурын өвөр рүү Сэлэнгэ мөрний сав газар шилжүүлэн суулгасан байна.

Буриадын аман түүхийн мэдээнд "*Цогто хун тайжийн аша Хонтогорын Охин хун тайж 1696 ондо орожи ерэн Оросын баатар сагаан хаанаас 1717 ондо хамагын анханы буряад Монголын тайша болжи байгалын үмнэхи буряадуудые захирхи эрхээр шагнуулсан хэдышье*

эрхэ мэдэлни зүвхөн Сонгоол отогоор хизаариллагдаха болсон бэлэй”⁹ (Цогт тайжийн ач Хонтогорын Охин хун тайж 1696 онд орж ирэн Оросын баатар цагаан хаанаас 1717 онд хамгийн анхны буриад Монголын тайш болж байгалийн өмнөх буриадуудыг захирах эрхээр шагнуулсан хэдий ч эрх мэдэл нь зөвхөн Сонгоол отгоор хязгаарлагдах бөлсөн билээ) хэмээжээ. Энэ мэдээнээс үзэхэд Охин тайжийн үрс 1822 оноос тайш цолоо гээж, “*Степной дум*” (талын хурал)-д “глава” (тэргүүн) гэсэн цолтой болсон ажгуу.

Б. Ринчен абугайн гурван үеийн намтартаа өгүүлснээр бол Охин тайж Оросод дагаар орохдоо хил сахина хэмээн гэрээ бичиг байгуулж, Цөх голын хавиар нутаг заалган суусан ажээ. Тэрхүү гэрээ бичиг Оросын архивт хадгалагдаж байгаа мэдээг Ринчен абугай олж сонссон байна. Охин тайжийн ууж байсан булгийг “*ökin bulay*” (Охин булаг), өвөлжиж байсан дов газрыг “*ökin dobu*” (Охин дов) хэмээн тахидаг болсон ажгуу. 1929 он хүртэл Охин тайжийн цагаан бартай хөх туг, өмсөж байсан хөө хуяг, ган дуулга, нум саадаг, сэлмийг “*ökin dobu*” (Охин дов) –ын овоон дээр тахиж, цэнгүүлэх ёслол хийдэг байсан байна.¹⁰

Оросын архивын баримтад “*ökin*” (Охин) хэмээх Монголын язгууртны нэр хэд хэд гардаг. Тэдний нэг бол Охин баатар зайсан бөгөөд Табунгутын нөлөө бүхий ноёдын нэг байв. Сэлэнгэ мөрний дунд урсгалын сав нутаг Хялга ба Цөх голуудын хооронд нутаглах монгол аймгуудыг Оросын баримт бичигт “табунгут” хэмээн нэрийдсэн байдаг.

Энэхүү Охин зайсан нь Охин тайж мөн үү? Охин зайсан аль эрт 1680 оны үеэс Оросын талыг баримталж ирсэн хийгээд 1689 оны 3-р сарын 12-нд Оросын элчин Ф. А. Головинтой Оросод дагаар орох гэрээ байгуулжээ. Тэр 1691 онд Монгол руу зугадаад 1695 онд буцаж ирсэн байна.¹¹

Эндээс үзэхэд Охин тайж нар анх Хорь Бабучийн нутагт хэсэг суужээ. Тэнд байхад нь Тойн гүүш очсон байна. Дараа нь тэд Цөх голын савд очих болсноор Сэлэнгийн буриадад харъяалагдах болжээ. Цөх гол Хэнтийн нурууны баруун хойд биеэс эх авч баруун зүг урсан Сэлэнгэ мөрний дунд урсгалд цутгадаг.

Оросын эрдэмтэн Е. М. Залкинд Охин зайсанг Сэлэнгийн бүх буриадын толгойлогч болсон. Түүнийг нас барсны дараа хөвүүн Лувсан залгамжилсан. Тайшийн албан тушаал үе улирсан тухай бичсэн байна.¹²

Убаш Дамбижалцанломбоцэрэнгийн 1868 онд зохиосон “*Сэлэнгийн Буриадын түүх*” номд Охины тухай дэлгэрэнгүй өгүүлдэг. Тэр “Чилэнгийн чонголнууд урьд хойно цуварч ирээд Охин нэрт ноёнтон байтал, Охинд бүр ойр төрлийн эр эм олноор босож ирээд, Охиныг сурагчлан олж учран урьд ирж Рустай танилцан Рус албат болж байсан тул, биднийг албатад багтаахыг зуурчилж болш гэв. Охин тэдийг найдуулж Охин хорих тэр шадар ойд байрлуулаад Сэлэнгийн Иданчийн ноёд цэрэг урьсан нь намайг алах бусдыг аваачихын тус олон цэрэг дээрэмчин ирж Охин хороо тэр шадар ойд байрлаж байнам. Тэдийг дарж болш хэмээн мэдүүлсэнд ноёд цэрэг ирж тэдийг алах тэр үймээнд нэгэн залуу эхнэр эм Охинд бэр болох тэр охины морины хударгаас шүүрээд авгай намайг асар намайг ав гэсэнд Охин түүнийг сундалдан гаргаж аваад гэргий хийв. Найман хөвүүн төрж төрж Охины найманы уг дэлгэрэв. Охины тэр гэргийг Авай эжий хэмээн үр үндсийг өргөмжилсөн нэрийг зас тавьсан. Тэнд Охины аймгаас төрсөн үр нар тэнд чуулж архи махтай, бөө удганаар урьд тахидаг мөргөдөг зантай агсан гэдэг. Охинд үүгээр шалтгаан болгож шивээ барьж үхэр буу хайрласан газрын эдэлбэр заасан мөнгөн сан ба Байгалийн энэ биеийн бүгд Буриадын тэргүүн тайш тушаалтай болж цагаан тамгат цааз зарлиг хүртсэн буй. Охин сайн эр мөн ч болов. Хайдаа бодолгүй өөрийн ганц алдар итгэлтэй болохыг санаж, төрөл төрөгсөдөө алуулсан цаг мянга долоон зуун арав гаран онд багцааж

⁹ Сайт *Бурятского народа* – Форум. <http://www.buryatia.forum>

¹⁰ *Бямбын Ринчен*, Монголын Шинжлэх Ухаан, боть V, УБ., 2003, т.140

¹¹ *Материалы по истории Русско-Монгольских отношений, 1685-1691.* сборник документов, Составитель Г. И. Слесарчук, М., 2000, стр.24, 191-192, 401-402, 427

¹² Е. М. Залкинд, *Из истории западного забайкалья в конце XVI начале XVIII вв.* Ученые записки серия востоковедческих наук, вып. I, 1949, стр.230

хуучид хэлэлцдэг болой”¹³ гэсэн уг мэдээ сэлт табунгутын Охин баатар зайсанд илүүтэй холбогдох мэт.

Энд өгүүлж буй Сэлэнгийн буриадуудын нэг толгойлогч Охин зайсанг Өвөр Монголоос ирсэн Охин тайжтай андууран хэлэлцэх, бичиглэх нь тун элбэг байна. Одоогоор 1691 оноос хойшхи Монгол-Оросын харилцааны баримт бичиг хараахан хэвлэгдээгүй байгаа тул Өвөр Монголоос Халхын нутгийг дайран Оросод дагаар орсон Охин тайжийн амьдрал, үйл ажиллагааг илүү тодорхойлох боломж хомс байна.

“*buriyad toyin gūši-yin aq-a degüü yurban-dur irege-edüi цаγ-un bayidal-un duridqal orusiba*” (Буриад тойн гүүшийн ах дүү гурванд ирээдүй цагийн байдлын дурдатгал оршив)-д нэр гарч буй “*aq-a degüü yurban*” (ах дүү гурав) бол Охин тайжтай хамтран дүрвэсэн “*baγan*”-Баян, “*baγciγar*”-Барчгар, “*nomin*”-Номин нар Авгын хошуудад нэр нөлөө бүхий ноёд байсан нь эргэлзээгүй юм.¹⁴

Дээрх бүхнээс үзэхэд, Б. Ринчен аругай эхийн талаараа Монголын их хаадын удмын хүн болох бөгөөд түүний дээд өвөг Халхын Цогт хунтайж Хөх нуур руу нүүснээр, хөвүүн Хонтугур нь Өвөр Монголын Шилийн голын чуулганы Авга хошуудад харъяалагдах болсон байна. Хонтугурын хөвүүн Охин тайж 1691 оны Долоннуурын чуулган дээр Манжийн эсрэг үймээн дэгдээхийг оролдсон нь бүтгэлгүйтэж, хойд зүг зугадан Оросын нутагт ороод Сэлэнгийн Буриадад харъяалагдах болсон байна.

¹³ *Летописи Селенгинских бурят, Убаши Дамби жалцан ломбо цэрэнова*, текст издал Н. Н. Поппе, М.-Л., 1936, стр.15-16

¹⁴ “*buriyad toyin gūši-yin aq-a degüü yurban-dur irege-edüi цаγ-un bayidal-un duridqal orusiba*”, хэвлэлд бэлтгэсэн Ж. Гэрэлбадрах, УБ., 2005, (хэвлэлд)